

Дуг		Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар, заалт	ХБ, ХБЗХТ ТАХ	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Үнэлгээ /%/
Ш	33				
ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО					
МУ-ын хууль					
1	1	<p>Цөмийн энергийн тухай 2009-07-16</p> <p>28.10 Энэ хуулийн 28.9-д заасан мөнгөн хөрөнгийн хэмжээг нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд учирч болох эрсдлийг харгалзан цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, байгаль орчны болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран гаргасан саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. /28.9: Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргээ биелүүлэх баталгаа болгон Төрийн санд мөнгөн хөрөнгө байршуулна/.</p>		<p>Уул уурхайн сайдаас Цөмийн энергийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9, 28,10 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор танилцуулга, захирамжийн төслийг ерөнхий сайдад танилцуулахаар бэлэн болоод байна.</p> <p>Цөмийн энергийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 13 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд “Арева Майнс ХХК-тай байгуулах гэрээний нөхцлийн талаар хэлэлцэн тохиролцож, улмаар 2016 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Ашигт малтмал, газрын тосны газар болон “Арева Майнс” ХХК-ийн хооронд Орд ашиглах гэрээг байгуулсан. Гэрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Цөмийн энергийн комиссын Ажлын алба зэрэг холбогдох яам, газрын саналыг тусгаж, хөрөнгө оруулагч тал /“Арева Майнс” ХХК/-тай саналын зөрүүтэй байсан зарим асуудлаар харилцан тохиролцож чадсан.</p> <p>Ерөнхий сайдын 2016 оны 21 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн дүгнэлт, Орд ашиглах гэрээний 4.2.1 дэх заалтыг үндэслэн “Арева Майнс” ХХК-ийн төслийн туршилтын үе шатанд байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх үүргийн баталгаа болгон Төрийн санд байршуулах мөнгөн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулж, ЗГХЭГ-г хүргүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Биелэлт 90%</p>	70%
	2	33.4 Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг Засгийн газар батална.		2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн ЦЭТХуулийн нэмэлт өөрчлөлт, 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын 72 дугаар тогтоолд зааснаар ЦЭК-ын эрх үүргийн талаар:	-/
	3	39.3 Цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх журмыг Засгийн газар батална.		- “цөмийн материалын тооллого, алдагдал, хорогдол, шилжилт хөдөлгөөн хийх журмыг батлах, - “цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон нийтлэг дүрэм, журмыг батлах”, - “цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацрагийн ослын хор уршгийг арилгах талаар яаралтай авах арга хэмжээний талаарх саналыг Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх” гэж заасан байдаг.	
	4	42.4 Цөмийн төхөөрөмж, цацрагтай холбогдолтой үйл ажиллагаанаас үүсэх хаягдлын аюулгүй ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.		Иймд эрхлэх чиг үүргийн дагуу ЦЭК-ын ажлын алба эдгээр асуудлыг хариуцан ажиллаж байна.	
2	2	<p>ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ (Шинэчилсэн найруулга) 2013-01-31</p> <p>10.1 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмыг геологи, уул уурхайн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн хяналтын төв байгууллагатай хамтран батална.</p>		<p>Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах дахь аюулгүй ажиллагааны журмын төслийг боловсруулж байна. Мөн “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн хүрээнд холбогдох байгууллага, мэргэжлийн холбоодтой санал солилцож, тэдгээрийн саналыг тусган нэгтгэх ажлыг зохион байгуулж байна.</p>	70

3	3	<p>ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2015-02-13</p> <p>3/12 дугаа “12.10.Цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч, цацрагтай ажиллагч нь ажлын онцлогт тохирсон тусгай хувцас, ялгах тэмдэг хэрэглэх бөгөөд ажлын тусгай хувцасны загвар, хэрэглэх журам, эдэлгээний хугацааг Цөмийн энергийн комисс батална.”</p>	<p>Чиг үүргийн хувьд ЦЭК хариуцан ажиллана.</p>	/-/
4	4	<p>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2015-02-18</p> <p>47.2 472.2.Энэ хуулийн 472.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална.</p>	<p>Стратегийн ач холбогдол бүхий Гацууртын алтны үндсэн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. ТЭЗҮ-ийг хүлээн авсаны дараа Орд ашиглах гэрээ байгуулах ба уг гэрээгээр ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг тохирч шийдвэрлэх юм.</p> <p>Биелэлт 90%</p>	70%

|